



**ТӨЛБӨР ТООЦООГ ҮНДЭСНИЙ МӨНГӨ ТЭМДЭГТЭЭР  
ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАХ  
ЧИГЛЭЛЭЭР ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЛААР**

Улаанбаатар хот

2013.10.24

**2013 ОНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР**

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2013 оны 9 дүгээр сарын 04-ний өдрийн 215 дугаар тушаалаар баталсан удирдамжийн дагуу дараах ажлын хэсгийн үрблэдэхүүнтэй шалгалтыг хийж гүйцэтгэсэн.

Шалгалтын ажлын хэсэг нийт 41 хуулийн этгээд болон иргэдийн гадаад валютын төлбөр тооцооны үйл ажиллагааг шалгасан бөгөөд илэрсэн зөрчилд үндэслэн ногдуулсан захиргааны арга хэмжээ дараах хүснэгтээр харуулав.

Салбар		Шалгалтад хамрагдсан хуулийн этгээдийн нэр	Торгуулийн дүн	Зөрчлийн тэмдэглэлийн дугаар
<i>Барилгын салбар</i>	1	“ОТБАР” ХХК	9,600,000	98
	2	“Илсон девелопмент” ХХК	9,600,000	100
	3	“Эйч Эс Би” ХХК	9,600,000	87
	4	“Өндөрбуянт холдинг” ХХК	9,600,000	88
	5	“Макс өргөө” ХХК	9,600,000	89
	6	“Камдер” ХХК	9,600,000	90
	7	“Сандэй” ХХК	9,600,000	91
	8	“Зуншин” ХХК	9,600,000	93
	9	“Монголианпропертис” ХХК	9,600,000	97
	10	“Хонкалогхоум” ХХК	-	-
	11	“Хонгрансфеко” ХХК	-	-
	12	“Тэдмэнт” ХХК	-	-
<i>Гадаад худалдаа, үйлчилгээ, түрээсийн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдүүд</i>	1	“Ситирийл эстэйт” ХХК	9,600,000	95
	2	“Туушин зочид буудал” ХХК	9,600,000	99
	3	“Форевер ливинг продактс” монголиа ХХК	9,600,000	92
	4	“Төгс интернэшнл” ХХК	9,600,000	98
	5	“Платиниум гэйт” ХХК	-	-
	6	“Эм Эн Ти прожект” ХХК	-	-
	7	“Монголиан девелопмент” ХХК	-	-
	8	“М энд Ж” ХХК	-	-
	9	“Голденмагнолиа” ХХК /nobilia mebel/	-	-
<i>Боловсролын салбар</i>	1	“Эм Ай Ю” дээд сургууль	-	-
	2	“Эскүүл гарден” ХХК /British	-	-

		school of Ulaanbaatar/		
	3	Улаанбаатар дахь олон улсын дунд сургууль /International school of Ulaanbaatar ISU/	-	-
	4	“Эй Эс Юу” ХХК /American school of Ulaanbaatar ASU/	-	-
	5	“Рояль-Академи” ХХК	-	-
	6	“Олонлог төв” бүрэн дунд сургууль	-	-
<i>Автомашинь худалдааны салбар</i>	1	“Наран моторс” ХХК	-	-
	2	“Вагнер ази автотив” ХХК	-	-
	3	“Моннисмоторс” ХХК	-	-
	4	“Бодь-Автотив” ХХК	-	-
	5	“Таван Богд” ХХК	-	-
	6	Хан өндөр авто маркет	-	-
	7	Улаанхуаран авто салон	-	-
	8	Баянзүрх моторс авто салон	-	-
	9	Дүнжингарав худалдааны төвийн гадна талбай дахь авто машин худалдаалж буй иргэн Ц.Батболд	-	-
	10	АСА циркийн гадна талбай дахь авто машин худалдаалж буй иргэд	-	-
	11	Замын цагдаагын газрын баруун талын зогсоолын талбай дахь авто машин худалдаалж буй иргэд	-	-
<i>Бусад</i>	1	МЦХ ТӨХХК	9,600,000	104
	2	ШШГЕГ газар	-	-
	3	Ашигт малтмалын газар	-	-
<b>НИЙТ</b>	<b>41</b>	-	<b>134,400,000</b>	

Шалгалтын ажлын хэсэг нийт 41 хуулийн этгээд болон иргэдийн гадаад валютын төлбөр тооцооны үйл ажиллагааг шалгасан бөгөөд салбар бүрээр дүгнэн үзвэл дараах байдалтай байна.

#### ***Барилгын борлуулалт, зуучлалын салбарын тухайд***

Шалгалтад хамрагдсан барилгын компаниудаас “Эйч Эс Би” ХХК, “Өндөрбуянт холдинг” ХХК, “Макс өргөө ” ХХК, “Камдер” ХХК, “Сандэй” ХХК, “Зуншин” ХХК, “Монголианпропертис” ХХК, “ОТБАР” ХХК зэрэг хуулийн этгээдүүд ажил үйлчилгээний үнийг ам.доллаар тогтоож байсан ба нийт **39,429,151** (Гучин есөн сая дөрвөн зуун хорин есөн мянга нэг зуун тавин нэг) ам долларын орлогын гүйлгээг гүйцэтгэсэн байна.

Шалгалтад хамрагдсан компаниудаас “Макс өргөө” ХХК, “Хонкалогхоум” ХХК, “Эм\_Эн Ти прожект” ХХК, “Монголианпропертис” ХХК, “Хонгрансфеко” ХХК-иуд Барилга орон сууц-2013 үзэсгэлэнд бараа үтээгдэхүүний үнийг ам доллараар сурталчилж байсан. Үүнээс “Хонгрансфеко” ХХК нь борлуулалт хийгээгүй бөгөөд орлогын гүйлгээ гараагүй байсан.

Барилгын компаниуд захиалгын болон борлуулалтын үнийн саналыг ам доллараар тогтоож төлбөр тооцоо хийх, гэрээ хийх, гадаад ажилчдын цалинг ам доллараар олгох, Монгол Улсын нутаг дэвсгэр дээрйг ажиллагаа явуулж буй хуулийн этгээд эд барилга угсралтын ажлын хөлсийг ам доллараар төлөх зэрэг нь хуулийг өрчиж байгаа нь нийтлэг хэлбэр гэж үзэж байна.

Барилгын салбарын туслан гүйцэтгэгч болох БНХАУ-ын хөрөнгө оруулалттай “Зуншин” ХХК нь барилга угсралт, гадна дотор заслын үйлчилгээг дотоодын компаниудад үзүүлэхдээ ихээхэн хэмжээний ам.доллаар гүйцэтгэсэн байна. Тухайлбал: “Зуншин” ХХК нь “Макс өргөө” ХХК, “Камдер” ХХК, “Илсон девелопмент” зэрэг томоохон компаниудын барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн ба тэдгээрээс “Макс өргөө” ХХК, “Камдер” ХХК-иуд нь иргэдээс авах орон сууцны захиалгын үнийг ам.доллаар тооцон авсан зөрчилтэй байна.

Цаашид барилгын салбарын захиалагч, гүйцэтгэгч болон туслан гүйцэтгэгчийн хооронд хийгдэж буй гэрээ, ажил үйлчилгээний үнийг хуулийн дагуу төгрөгөөр гүйцэтгүүлснээр нэг талаар эцсийн захиалагч иргэний төлөх төлбөр төгрөгөөр илэрхийлэгдэх нөхцөл бүрдэх талтай байна.

#### ***Гадаад худалдаа, үйлчилгээ, түрээсийн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдүүд***

“Форевер ливинг продактс монголиа” ХХК бүтээгдэхүүний борлуулалтаа 2011 оноос хойш одоо хүртэл тооцох нэгжээр гүйцэтгэсэн, “Төгс интернэшнл” ХХК бүтээгдэхүүний үнээ ам доллароор тогтоож, тухайн үеийн банкны ханшаар тооцож, төгрөгт шилжүүлэн тооц соор байна. Эдгээр компаниуд Монголбанкны албан ёсны зөвшөөрөл аваагүй байна.

“Ситирийл эстэйт” ХХК, “М энд Ж” ХХК-ийн захирал иргэн Ч.Бямбаарэн н ар түрээсийн гэрээг ам доллароор илэрхийлж нэхэмжилсэн, “Туушин зочид буудал” ХХК нь зочид буулын өрөөний төлбөр, холбогдох үйлчилгээний үнийг ам доллароор илэрхийлж үйлчлүүлэгчдээс нэхэмжлэн авсан зэрэг зөрчил илэрсэн.

#### ***Автомашин худалдааны салбарын тухайд***

“Наран моторс” ХХК, “Вагнер ази автмотив” ХХК, “Моннисмоторс” ХХК, “Бодь-Автотив” ХХК, “Таван Богд” ХХК зэрэг 2012 онд шалгалтанд харагдаж байсан хуулийн этгээдүүд шалгалтаар өгсөн үүрэг даалгаварыг хэрэгжүүлж зөрчлөө арилгасан байна. Япон автомашин борлуулж буй зарим иргэдийн ажиллагааг шалгахад үнийг төгрөгөөр илэрхийлж төлбөр тооцоог гүйцэтгэсэн байна. Үүнд: Хан өндөр авто маркет /иргэн О.Анхбаяр/, Улаанхуаран авто салон /иргэн Б.Ганцог/, Баянзүрх моторс авто салон /иргэн Ч.Батсайхан/.

Харин Америк, Арабын улсуудаас автомашин импортоор оруулж ирж буй иргэд автомашин үнийг ам доллараар илэрхийлсэн зөрчил илэрсэн. Шалгалтын ажлын хэсэг АСА циркийн гаднах талбай, Дүнжингарав худалдааны төвийн гаднах талбай, Замын цагдаагийн газрын хажуугийн зогсоол дахь автомашин борлуулж буй иргэдийн ажиллагааг шалгах гэсэн боловч тэдгээр иргэд өөрсдийн нэр болон бусад мэдээллийг өгөхгүй, шалгуулахаас эрс татгалзаж зугтаж байсан ба зарим иргэд шалгалтыг ажлын хэсэгтэй бүдүүлгээр харьцаж байлаа. Хорооны зүгээс зарим онцлог шалгалтын объектыг шалгах хууль хүчний байгууллагатай хамтарсан хэлбэрээр шалгалтыг явуулж байх шаардлагатай байна.

#### ***Боловсролын салбарын тухайд***

Боловсролын салбартай холбогдуулж Хорооны 261662 утсанд Олонлог сургууль, Улаанбаатар дахь олон улсын дунд сургууль, Эм Ай Юу дээд сургуулиудыг ам.доллаар сургалтын төлбөрөө авч байна гэсэн гомдол ирсэн боловч шалгалсан баримтын хүрээнд зөрчил илрээгүй болно.

Боловсролын салбарт Хороо болон Шудрага өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газраас удаа дараагийн шалгат хийгдэж байсан тул зөрчил арилсан байна.

#### ***Бусад***

“Монголын цахилгаан холбоо” ТӨХХК улс хоорондын ярианы 001 гарцын үйлчилгээний тарифыг тооцох нэгжийг ашиглан тогтоож байсан. Үүнд үндэслэн захиргааны арга хэмжээ авахаар ажлын хэсгээс тогтсон.

Дээрх төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдэд цаашид бараа, ажил үйлчилгээний үнийг үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлж төлбөр тооцоог гүйцэтгэх,

бусад бүхий л танилцуулга, сурталчилгааны баримт бичиг гэрээний үнийн саналыг зөвхөн төгрөгөөр илэрхийлж, хуулийг хэрэгжүүлэх талаар холбогдох заавар, зөвлөгөө өгсөн.

Шалгалтад хамрагдсан 16 хуулийн этгээдэд дараах нийтлэгүүрэг, даалгаврыг Улсын байцаагчийн гарын үсэг бүхий зөрчлийн тэмдэглэлээр хүргүүлсэн. Үүнд:

1. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийг үйл ажиллагаандаа дагаж мөрдөх, гаргасан зөрчил дутагдлыг арилгах, дахин давтахгүй байхыг анхааруулах;

2. Цаашид хуулийг хэлбэрэлтгүй мөрдөж ажиллах, зөрчсөн тохиолдолд хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д “зөрчлийг арилгуулах талаар шаардлага тавьж тухайн үйл ажиллагаанаас олсон орлогыг хурааж улсын орлого болгох”, 6.1.2-д заасны дагуу “.....хуулийн этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50–100 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох буюу үйл ажиллагаа эрхлэх эрхийг хүчингүй болгуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах” гэж тус тус заасны дагуу холбогдох захиргааны шийтгэл ногдуулах.

### **ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР**

Монгол Улсын Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийг нийгэм, эдийн засгийн салбарт үйл ажиллагаа явуулж буй бүх хуулийн этгээдэд мөрдүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр Санхүүгийн зохицуулах хорооноос дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг анхааруулаад байна.

Тухайлбал, 2009-2013 онуудад хийж гүйцэтгэсэн газар дээрх шалгалтад хамрагдсан хуулийн этгээдэд хуулийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаагүй, дахин зөрчсөн тохиолдолд Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д “зөрчлийг арилгуулах талаар шаардлага тавьж тухайн үйл ажиллагаанаас олсон орлогыг хурааж улсын орлого болгох”, 6.1.2-т “...зөрчлийг арилгаагүй бол зөрчлийг арилгах хүртэлх хугацаанд .... хуулийн этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50–100 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох буюу үйл ажиллагаа эрхлэх эрхийг хүчингүй болгуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах” гэж тус тус заасны дагуу захиргааны шийтгэл ногдуулахыг хатуу анхааруулсан.

Түүнчлэн холбогдох хуулиудийн уялдаа холбоог хангуулах асуудалд анхаарлаа хандуулж ажиллахаар төлөвлөж байна. Үүнд:

1. Төрийн болон төрийн өмчийн компаниудад хуулийн дагуу ам доллар аар гүйцэтгэж буй төлбөр тооцоог УИХ-ын 2009 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар батлагдсан Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн заалтын дагуу Онцгой албан татварын тухай хууль, Ашигт малтмалын тухай хуулийг шинэчлэх асуудлыг холбогдох байгууллагад санал оруулж шийдвэрлүүлэх;

2. Арилжааны банкууд барилгын болон барилга угсралтын компаниудад ам доллароор зээл олгож байгаа нь ам доллараар гүйлгээ хийх нөхцөл бүрдүүлж, валютын ханшны өсөлтөөр аж ахуйн нэгж их хэмжээний алдагдалд орж байгааг анхаарч Монголбанктай хамтран асуудлыг шийдвэрлүүлэх;

3. Хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, төгрөгт итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх, валютын ханшийн эрсдэлтэй холбоотой асуудлыг нэгж цэгцлэх зорилгоор нийгэм, эдийн засгийн салбаруудад хэсэгчилсэн шалгалт хийх, шаардлагатай тохиолдолд төрийн бусад байгууллагуудтай хамтран шалгалт хийх, хуулийг хэрэгжүүлэх талаарх зар сурталчилгааг олон нийтэд хүргэх ажлыг эрчимтэй зохион байгуулах;

4. Гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоох, гэрээний үнийг ам доллараар илэрхийлж буй үйл ажиллагаанд нэгдсэн шалгалт хийх, шалгалтаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг тухай бүр хянаж, хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар арга хэмжээ авч, бараа, ажил

үйлчилгээний төлбөрийг гадаад валют, тооцох нэгжийг ашиглан гүйцэтгэж байгаа зөрчлийг таслан зогсоох шаардлагатай;

5. Төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодод Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийг хэрэгжүүлэх талаар албан тоот хүргүүлэх.

## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО